



**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/232

Улаанбаатар хот

Болзолт уралдаан зарлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 39 дүгээр зүйл, Монгол улсын Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, Авто замын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.4, Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/22 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/15 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөр хураалтыг эрчимжүүлэх зорилгоор дүүргийн хороодын дунд зарлах болзолт уралдааны удирдамжийг хавсралтаар баталсугай.

2. Дүүргийн хэмжээнд авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөр хураалтын эрчимжүүлсэн ажлыг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийг Татварын хэлтсийн холбогдох зардлаас санхүүжүүлэхийг Татварын хэлтэс /Х.Наранцэцэг/-т зөвшөөрсүгэй.

3. Тээврийн хэрэгсэл эзэмшигчдийг авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөр хураах, албан журмын даатгал, техникийн хяналтын үзлэгт хамруулах ажлыг хуулийн хугацаанд зохион байгуулж, үр дүнг сар бүр танилцуулахыг Эдийн засаг, худалдаа үйлчилгээ, тохижилт нийтийн аж ахуйн асуудал хариуцсан төслийн удирдагч /Э.Батбилэг/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ОДОНТУЯА

Баянгол дүүргийн Засаг даргын
2019 оны .05. дугаар сарын .01. –ны өдрийн
А/232 дугаар захирамжийн хавсралт



АВТО ТЭЭВРИЙН БОЛОН ӨӨРӨӨ ЯВАГЧ ХЭРЭГСЛИЙН АЛБАН ТАТВАР
АГААРЫН БОХИРДЛЫН ТӨЛБӨР, АВТО ЗАМ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР
ХУРААЛТЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ЗОРИЛГООР ДҮҮРГИЙН ХОРООДЫН ДУНД
ЗАРЛАХ БОЛЗОЛТ УРАЛДААНЫ УДИРДАМЖ

Нэг.Зорилго.

Дүүргийн хэмжээнд Монгол улсын Авто тээврийн болон өөрөө явагч Монгол улсын Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, Агаарын бохирдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, Авто замын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.4, Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/22 дугаар тушаал, Нийслэлийн засаг даргын 2019 оны А/15 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Баянгол дүүргийн хэмжээнд Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, Агаарын бохирдлын төлбөр, Авто зам ашигласны төлбөрийг хураах, төсвийн орлогыг бүрдүүлэх, тээврийн хэрэгсэл эзэмшигчдийг албан татварт бүрэн хамруулахад оршино.

Хоёр.Хамрах хүрээ:

Дүүргийн 23 хороод оролцоно.

Гурав.Хэрэгжүүлэх хугацаа:

2019 оны 05 дугаар сарын 01-нээс 05 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд зохион байгуулагдана.

Дөрөв. Болзол:

Хорооны хэмжээнд албан татвар, төлбөр хураах ажлыг татварын хэлтэстэй хамтран зохион байгуулж, тээврийн хэрэгсэл эзэмшигчдийг бүрэн хамруулах;

Татварын хэлтсээс гаргасан судалгааны дагуу авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөр төлөөгүй тээврийн хэрэгсэл эзэмшигчийн хаягаар мэдэгдэл хүргүүлэх ажлыг, Татварын хэлтэс, хорооны цагдаатай хамтран зохион байгуулах;

Албан татвар, төлбөрөө төлөөгүй, техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй замын хөдөлгөөнд оролцож байгаа автотээврийн хэрэгслийг илрүүлж, холбогдох газруудад мэдээлэх

Албан татвар, төлбөр хураахтай холбогдсон мэдээлэл, сурталчилгааг нийтэд түгээх, сурталчлах ажлыг зохион байгуулах.

Тав.Уралдааны болзлыг дүгнэх

Болзолт уралдааныг дүүргийн Засаг даргын 2019 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн А/11 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 2019 оны 06 дугаар сарын 10-ны дотор дүгнэнэ.

Зургаа.Шагнал, урамшуулал

| | |
|--------------|---------------------|
| 1-р байр – 1 | 500.0 мянган төгрөг |
| 2-р байр – 1 | 300.0 мянган төгрөг |
| 3-р байр – 1 | 150.0 мянган төгрөг |